



## Supporting your child's wellbeing during suspension

Parent/carer factsheet

# Сургуулиас түр чөлөөлөгдсөн байх хугацаанд хүүхдийнхээ сайн сайхан байдалд дэмжлэг үзүүлэх тухай

## Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

### Хүүхэддээ хэрхэн дэмжлэг үзүүлэх тухай

Сургуулиас түр чөлөөлөгдсөн байх хугацаанд хүүхдийнхээ эрүүл мэнд, сайн сайхан байдалд дэмжлэг үзүүлэхийн тулд юуны түрүүнд мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөө мэдээлэл авах нь зүйтэй юм. Хүүхдийнхээ сайн сайхан байдалд дэмжлэг үзүүлэхэд тань туслах практик зөвлөгөө, мэдээллийг дараах холбоосуудаас авна уу. Үүнд:

- Сайн сайхан байдал ([Wellbeing](#))
- Зөвлөгөө авах болон сэтгэлзүйн үйлчилгээнүүд ([Counselling and psychology services](#))

Сургууль болон сурагчийн гэр бүл хоорондоо эерэг, нээлттэй харилцаа холбоотой байх нь уг сурагчид амжилттай суралцах боломжийг бүрдүүлдэг.

- Хүүхэддээ өөрийг нь сургуулийнхаа үнэ цэнэтэй гишүүн гэдгийг нь сануулж байгаарай.
- Ямар нэгэн санаа зовнисон адуудал гарвал сургуульд нь мэдэгдэж байгаарай.
- Хүүхдийнхээ сургуульдаа сурах явцад оролцох оролцоог дэмжих стратегийг боловсруулж хэрэгжүүлэхэд нь сургуулийн багтай хамтран ажиллаарай.
- Хүүхдийнхээ сургуульдаа буцан орох явцыг төлөвлөх уулзалтанд оролцоорой. Энэ уулзалт нь биеэр ирэх, онлайнгаар эсвэл утсаар зохион байгуулагдах боломжтой.
- Эерэг, аюулгүй, бүгдийг тэгш хамруулсан мөн хүндэтгэлтэй сурах орчинг бүрдүүлдэг зохистой зан авируудын талаар хүүхэдтэйгээ ярилцаарай.
- Хүүхэд өөрийнхөө санаа бодлыг бусадтай эелдэгээр, идэвхитэй хуваалцдаг байхыг нь урамшуулан дэмжээрэй.

### Сургуулиас түр чөлөөлөгдсөн байх хугацаанд гэрээсээ суралцах тухай

- Сургуулиас түр чөлөөлөгдсөн байх хугацаанд сургуулийн ажилтан та болон таны хүүхэдтэй тогтмол холбоотой байх болно.
- Өдөрт хичээлээ хийх тогтсон цагийг товлох, чимээ шуугиангүй орчин бүрдүүлэх, мөн хичээл нь хэр явцтай байгааг нь асуух замаар хүүхэддээ суралцахад нь туслаарай.
- Тэдэнд завсарлагаа олгож, ус уулган мөн стрессдсэн эсвэл санаа зовнисон үед нь тусалж байгаарай.
- Идэвхитэй хөдөлгөөн хийх цаг гаргаж өгөөрэй.
- Хүүхдийнхээ технологийн аюулгүй хэрэглээг хянаарай. Технологийг зохистой ашиглах тухай ([Using technology](#)) сайт дээр танд хэрэгтэй мэдээлэл, эх сурвалжууд байгаа болно.

### Хэрэгцээт холбоосууд

- Суралцах багц ([Learning packages](#))
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суралцах болон дэмжлэг үзүүлэх тухай зөвлөгөө ([Disability learning and support advice](#))
- Зан авирыг дэмжих гарын авлага ([Behaviour support toolkit](#)): Хэрвээ таны хүүхэд сургуулиас түр чөлөөлөгдсөн бол юу хийх тухай
- Хүүхэддээ гэрээсээ суралцахад нь туслах тухай ([Helping your child learn from home](#))
- [Хүүхдэд Туслах Шугам](#) нь 5-аас 25 насны хүүхэд залууст зориулсан Австрали дах цорын ганц үнэгүй утсаар зөвлөгөө авах үйлчилгээ юм. 1800 55 1800 дугаараар залгаарай.

### Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.